АЙМАГ, НИЙСЛЭЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАРТ 2024 ОНД ХҮРГҮҮЛСЭН
ТУШААЛ, ЗӨВЛӨМЖ, ЧИГЛЭЛ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

Баянзүрх дүүрэг 2024.12.10

| № | Дугаар | Огноо | Хүргүүлсэн нэгж | Товч утга | Хэрэгжилт | Биелэлт /хувь/ |
|---|---|---|---|---|---|---|
| *НЭГ. АЙМАГ, НИЙСЛЭЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛСЭН ТУШААЛ* | | | | | | |
| 1.1 | 01/4 | 24/01/02 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Судалгаа ирүүлэх тухай | Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “ХАСХОМ-1” буюу “ХАСХОМ-ийн 2023 оны тайлан”-ийн маягт, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалын 3, 4 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсан “ХАСХОМ-2” маягтын дагуу 2023 онд 42 албан тушаалтан “ХАСХОМ” гаргаж 2024 оны 02 дугаар сарын 20-нд НДЕГ-т тайланг хүргүүлсэн. | 100% |
| 1.3 | 01/77 | 24/01/10 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай А/02 дугаар тушаал, үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай А/03 дугаар тушаал хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон сангийн 2024 оны төсвийн батлагдсан хуваарaар зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн сахилга батыг ханган ажиллаж байна. Батлагдсан төсвийн хүрээнд багтаан нийт орлого 58 671,1 сая биелэлт 97% , нийт зардал нийт 89,2 сая төгрөгийг зарцуулан ажиллаа. | 100% |
| 1.4 | 05/241 | 24/02/01 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Төсвийн орлогын сар, улирлын хуваарийг батлах тухай тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах тухай | Төсвийн орлогын сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 1.5 | 01/565 | 24/03/21 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг батлах тухай А/34 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах тухай | Үйл ажиллагааны зардлын батлагдсан хуваарийн дагуу тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 1.6 | А/38 | 24/03/25 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | НДЕГ-ын даргын А/38 тоот тушаалаар тус газрын дэргэдэх эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зөвлөлийн бүрэлдэхүүний төрөлжсөн мэргэшлийн эмч нарыг Эрүүл мэндийн магадлалын дүрмийн 2 дахь хэсгийн 2.15 дахь заалтад заасан ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг харгалзан дүүргийн Эрүүл мэндийн газартай зөвшилцөн саналыг хүргүүлэн ажиллалаа. Тушаалын хэрэгжилтийг ханган шинэчлэгдсэн бүрэлдэхүүнээр эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлыг тогтмол хэвийн явуулж байна. | |
| 1.7 | 04/705 | 24/04/05 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | А/43 Тушаал хүргүүлэх тухай | НДЕГ-ын А/43 тоот тушаалаар даатгуулагчийн төрөл кодыг нэмж баталсан. Мэдээллийг ажил олгогчид хүргэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 1.8 | 01/753 | 24/04/09 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай А/47 дугаар тушаал, үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай А/49 дугаар тушаал хүргүүлэх тухай | НДЕГ-ын даргын А/49 тоот тушаалаар АО-ч даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд 9753,3 мянган төгрөгийн төсвийг нэмж санхүүжүүлэхээр сангийн төсвийн тодотгол хийгдсэн байна. | 100% |
| 1.9 | 02/864 | 24/04/24 | Тамгын газрын дарга Б.Батсүх | Аймгийн Нийгмийн даатгалын газрын бүтэц зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай А/51 дүгээр тушаал хүргүүлэх тухай | НДЕГ-ын даргын 2024 оны А/51 дугаар тушаалаар баталсан 75 бүтэц орон тоог шинэчлэн баталж, сул орон тоог Төрийн албаны хуульд заасны дагуу тусгай шалгалтын захиалга өгч 11 албан хаагчийг баталжуулсан. | 100% |
| 1.10 | А/20 | 24/02/08 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай | **https://bayanzurh.ndaatgal.mn/** сайтанд нээлттэй мэдээллийг байршуулсан. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Тус газрын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Нээлттэй өгөгдөл мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт байршуулах, хяналт тавих үүрэг бүхий ажилтнаар Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн Г.Энхбаярыг томилон ажиллуулж байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай” А/20 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаар заалтын дагуу 48 төрлийн мэдээллийг 2024 оны 12 сарын байдлаар бүрэн байршуулсан байна. | |
| 1.11 | 01/964 | 24/05/08 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг батлах тухай А/67 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах тухай | Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг батлах тухай А/67 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажилласан. | 100% |
| 1.12 | 05/1033 | 24/05/16 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | 2024 оны 05 сарын 15-ний өдрийн Урамшуулал олгох тухай А/75 дугаар тушаал хүргүүлэх тухай | НДЕГ-ын даргын 2024 оны А/75 дугаар тушаалыг үндэслэн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн болон төсвийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргасан Сангийн мэргэжилтэн О. Халиунаа, Үйл ажиллагааны нягтлан бодогч Г. Ануужин нарт урамшуулал олгосон. | 100% |
| 1.13 | 04/1054 | 24/05/20 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Тушаал хүргүүлэх тухай | 2024 оныг нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарласантай холбоотой сайн дурын даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор НДГ-ын даргын А/08 тоот тушаалаар нийт байцаагчдын дунд уралдаант 2 сарын “Хамралтын аян” зарлан ажиллаа.<br><br>Жилийн эцсийн байдлаар Ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажлаас чөлөөлөгдөн *СДД-д хамрагдсан 582, малчин 72, 0-03 насны хүүхдээ асарч буй 112 эх, ХБХАБуй эцэг эх 225, нийт 991 иргэнийг* сайн дурын даатгалд шинээр хамруулсан. | 100% |
| 1.14 | 05/1101 | 24/05/28 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Маягтын загвар батлах тухай А/83 дугаар тушаал хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй байгууллагын банкин дахь харилцах “Дансны зарлагын гүйлгээг түр зогсоож шимтгэл алданги төлүүлэх тухай” мэдэгдэл, “ Дансны зарлагын гүйлгээг нээх” тухай зөвшөөрлийн шинэчлэн батлагдсан маягтыг журмын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 1.15 | 04/1134 | 24/05/31 | Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/91 дүгээр тушаалын хавсралт хүргүүлэх тухай | 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг маягтын дагуу хуулийн хугацаанд гаргаж хүргүүлсэн байна. | 100% |
| 1.16 | 01/1136 | 24/05/31 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дүгээр тушаал хүргүүлэх тухай | ХНХЯ-наас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа хөтөлбөрийн хэрэгжүүлэх мөн иргэн аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгохдоо “ Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт” авах, дэмжлэг авсан | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацаанд нийгмийн даатгалд хамруулах талаар Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран ажиллаж байна. | |
| 1.17 | 01/1087 | 24/05/24 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай А/80 дугаар тушаал хүргүүлэх тухай | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг үүрэг болгосон. Ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээний зардлын төсвийн хувиарыг 2,4 сая төгрөгөөр урагшлуулан хуваарлаж ирүүлсэн байна. | 100% |
| 1.18 | 01/1231 | 24/06/13 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Төсвийн хуваарь хүргүүлэх тухай Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажилагааны урсгал зардалд өөрчлөх А/100 дугаар тушаал хүргүүлэх тухай | Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг батлах тухай А/67 дугаар тушаалыг хүчингүй болгож, 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/100 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 1.19 | 01/1322 | 24/06/17 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Төсвийн хуваарь хүргүүлэх тухай Нийгмийн даатгалын сангийн төсвийн хуваарь өөрчлөх А/106 дугаар тушаал хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулсны дагуу холбогдох өөрчлөлтийн дагуу өөрчлөлт оруулан төсвийн сахилга батыг ханган ажилласан. | 100% |
| 1.20 | 02/1431 | 24/06/26 | Тамгын газрын дарга Б.Батсүх | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргын 2024 оны 06 дугаар 13-ны өдрийн А/105 тоот тушаалаар батлуулан хүргүүлэх тухай | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшлүүлж танхимаар болон цахимаар 4 удаа зохион байгуулав.<br>*/Сургалтын тайланд дэлгэрэнгүй тусгагдсан/*<br><br>2024 онд Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах,соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газрын албан ёсны пэйж хуудас болон вэб хуудсанд<br>✓ Иргэн та нийгмийн даатгалд заавал даатгуулаарай<br>✓ Нийгмийн даатгал таныг эрсдэлээс шүхэр мэт хамгаална<br>✓ Даатгалтай ирээдүй таны гарт<br>Эрсдэлгүй ирээдүйг хамтдаа бүтээцгээе уриан доор 2 цуврал видео танилцуулга шторкыг хийж газрын Facebook хуудсаар түгээн дэлгэрүүлсэн.<br>Аймгийн ЗДТГазар Авлигатай тэмцэх газартай хамтран албан хаагчдыг авлигын гэмт хэрэгт өртөх эрсдлийг бууруулах, | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор 2024 оны 06 сарын 12-ны өдөр зохион байгуулсан сургалтанд газрын 35 албан хаагч хамрагдсан.<br>Төрийн аудитын газраас харилцагч байгууллагуудын дунд зохион байгуулсан Авлигын тухай мэдлэг сорих АХА тэмцээнд Нэг цэгийн үйлчилгээ хариуцсан байцаагч О. Анужин тэргүүн байр эзэлж амжилттай оролцов.<br>“Авлигагүй бүс” уриан дор “Авлигын эсрэг нэгдье”, “Үгүй гэж хэлээд өөрчилье” сэдвээр ёс зүй, шударга байдлыг уриалсан 2 контентийг түгээн дэлгэрүүлж сошиалаар нийтэд хүргэн ажиллав.<br>АТГ-аас зохион байгуулсан Авлигын эсрэг төрийн байгууллагын удирдах ажилтны сургалтад Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Д. Сэлэнгэ хамрагдав. | |
| 1.21 | А/125 | 24/07/09 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Төсвийн шууд захирагч нарт урамшуулал олгох тухай | Төсвийн шууд захирагч нарт урамшуулал олгох тухай А/125 дугаар тушаалын хавсралтын дагуу гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээ, үндсэн цалингийн хувь хэмжээний дагуу тооцож мөнгөн урамшуулалыг олгосон. | 100% |
| 1.22 | А/130 | 24/07/16 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Төсвийн хуваарь хүргүүлэх тухай /Сангийн урсгал зардал/ | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулсны дагуу холбогдох өөрчлөлтийн дагуу өөрчлөлт оруулан төсвийн сахилга батыг ханган ажилласан. | 100% |
| 1.23 | 01/1544 | 24/07/18 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Төсвийн хуваарь хүргүүлэх тухай /Үйл ажиллагааны урсгал зардал/ | 2024 оны төсвийн хуваарийг батлах тухай А/100 дугаар тушаалыг хүчингүй болгож, 2024 оны 07 дугаар сарын 16-ний өдрийн А/129 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаан бүтэц, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу ажлаас чөлөөлөгдсөн үйлчлэх ажилтан Л.Батмөнх-д нэг удаагийн буцалтгүй тусламж 2700.0 мян.төгрөг олгосон. | 100% |
| 1.24 | 07/1665 | 24/08/06 | Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтанцэцэг | 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/137 дугаарын тушаалыг хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулсны дагуу холбогдох өөрчлөлтийн дагуу өөрчлөлт оруулан төсвийн сахилга батыг ханган ажилласан. | 100% |
| 1.25 | 03/1697 | 24/08/14 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Ажлын цаг ашиглалт, бүтээмж, хариуцлагыг сайжруулах тухай А/139 дүгээр тушаалыг хүргүүлэх тухай | Ажилтнуудын цаг ашиглалтын бүртгэлийг дотоод үйл ажиллаганы удирдлагын нэгдсэн систем ABLE –ээр бүртгэн хяналт тавин ажиллаж байна. 2024 онд Ажлын цаг ашиглалт, амралт чөлөө олгох журмыг шинээр боловсруулан газрын | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээнд 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллаж байгаа болно. | |
| 1.26 | 01/1911 | 24/09/13 | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай тушаал хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулсны дагуу холбогдох өөрчлөлтийн дагуу өөрчлөлт оруулан төсвийн сахилга батыг ханган ажилласан. | 100% |
| 1.27 | 06/2006 | 24/09/27 | Шимтгэл хураалтын удирдлага, аргазүйн газрын дарга Б.Батсүх | Аян зохион байгуулах тухай А/162 тоот тушаалыг хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн А/162 тоот тушаалаар баталсан Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах аянаар хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулж, хамралт, орлого өр авлага хариуцсан байцаагч нарт танилцуулан ажиллаа. Өр авлага барагдуулах шат дараалсан арга хэмжээг авч ажилласнаар 59,647.1 сая төг авлагыг 34,868.1 болгон бууруулан ажлын биелэлтийг гарган нотлох баримтын хамт хугацаанд хүргүүллээ. | 100% |
| 1.28 | 06/2087 | 24/10/07 | Шимтгэл хураалтын удирдлага, аргазүйн газрын дарга Б.Батсүх | Тушаал хүргүүлэх тухай | Нийгмйин даатгалын авлага барагдуулах А/199 тушаалын дагуу шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/169 тоот тушаалаар батлагдсан албан мэдэгдэл, өр авлага барагдуулах гэрээ, уулзалтын тэмдэглэл зэрэг маягтуудыг хэрэглэж хэвшлээ | 100% |
| 1.29 | 03/2164 | 24/10/18 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Тушаал хүргүүлэх тухай | Нийгмийнг даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтыг зохион байгуулахтай холбогдуулан тус газраас орвол зохих 22 байцаагчаас 1 байцаагч шилжсэн, 2 байцаагч эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдөж, 19 байцаагч шалгалтад хамрагдсан. | 100% |
| 1.30 | 01/2169 | 24/10/21 | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Журамд өөрчлөлт оруулах тухай А/29 тоот тушаалыг хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийн хэмжээг 5-10 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой 28 улсын байцаагчийн мэргэжлийн зэргийн хувийг нэмэгдүүлэн тооцож олгосон. | 100% |
| 1.31 | 01/2192 | 24/10/23 | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,бодлогын хэрэгжилт, | Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай тушаал хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулсны дагуу холбогдох өөрчлөлтийн дагуу өөрчлөлт оруулан төсвийн сахилга батыг ханган ажилласан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | | | |
| 1.32 | 03/2318 | 24/11/07 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Тушаал хүргүүлэх тухай | НДЕГазрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 03/2318 дугаар албан бичгийн дагуу тус газрын мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй 1 албан хаагчийн нэмэгдлийг 25%-иар 2024.11.01-ны өдрөөс эхлэн нэмэгдүүлэн олгож эхэлсэн. | 100% |
| 1.33 | 01/2425 | 24/11/25 | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай тушаал хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулсны дагуу холбогдох өөрчлөлтийн дагуу өөрчлөлт оруулан төсвийн сахилга батыг ханган ажилласан. | 100% |
| 1.34 | 01/2472 | 24/11/29 | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай А/217 тушаал хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг сурталчилах сургалтыг зохион байгуулах сургалтын байгууллагыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж сургалтыг үр дүнтэй зохион байгуулан тайланг 2024 оны 01 дүгээр сард хүргүүлэхээр ажиллаж байна. | 100% |
| ***Биелэлтийн дундаж- 100 хувь*** | | | | | | |
| *ХОЁР. АЙМАГ, НИЙСЛЭЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ* | | | | | | |
| 2.1 | 01/82 | 24/01/10 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Зөвлөмж хүргүүлэх тухай | Тэтгэврийн олголтыг сар бүрийн 01 ний өдөр арилжааны 5 банкаар тогтмол олгож ажиллаа. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны батлагдсан зардлын төсөв 188,457,468.8 мян.төгрөг зарцуулахаас 185,787,835.2 мян.төгрөгийн зардал зарцуулж зардлын биелэлт 98,5% буюу 2,669,633.6 мян.төгрөгийн зардал хэмнэгдсэн байна.<br>-Тэтгэврийн зардал 165,789,318.1 мян.төг<br>-Тэтгэмжийн зардал 9,048,859.2 мян.төг<br>-ҮОМШӨ-ний сангийн зардал 6,837,211.4 мян.төг<br>-Ажилгүйдлийн зардал 4,112,446.5 мян.төг зарцуулсан.<br>Тэтгэврийн сангийн зардал нь нийт зардлын 89,4%-ийг эзлэж байна. | 100% |
| 2.2 | 01/137 | 24/01/16 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | АО-н нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтыг чирэгдэл учруулалгүйгээр цаасаар гаргаж өгч ажиллах тухай | Нийгмийн даатгалын системийн шинэчлэлтэй холбоотой *Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн талаарх тодорхойлолт*-ийг тендер, тусгай зөвшөөрөл сунгах зэрэг зориулалтаар хүсэлт ирүүлсэн 212 ажил олгогчид цаасаар гарган өгч ажилласан. | 100% |
| 2.3 | 01/200 | 24/01/26 | Нийгмийн даатгалын ерөнхий | Зөвлөмж хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нөхцөлд хангасан даатгуулагчидад | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын дарга Л.Мөнхзул | | жирэмсний болон амаржсаны тэтгэмж улсын бүртгэлийн хаягаар ирсэн даатгуулагчидад хуулийн дагуу олгож байна. | |
| 2.4 | 01/187 | 24/01/25 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Зөвлөмж хүргүүлэх тухай | Дархан-Уул аймгийн нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны А/03 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрмийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 2.5 | 03/273 | 24/02/05 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Үнэлгээний танилцуулга хүргүүлэх тухай | Төсвийн төвлөрүүлэн захирагчаас төсвийн шууд захирагч нартай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 93.6 хувиар дүгнэсэн байна. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орлогын төлөвлөгөө биелүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага бууруулах талаар онцгой анхаарч ажилласан. | 90% |
| 2.6 | 01/312 | 24/02/08 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Зөвлөмж хүргүүлэх тухай | НД-ын багц хуулийн шинэчлэлтэй холбоотой шинээр мөрдөх зүйл заалтыг хэрхэн мөрдөн ажиллах талаар ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>1. Дараалсан 6 эсхүл 7 жилийн дундажаар тэтгэврээ тогтоолгосон иргэдийн 3815 хүсэлтийг хүлээн авч 5 жилээр шинэчлэн тогтоосон.<br>2. Тэтгэврийн тусгай зохицуулалт буюу нас барсан тэтгэвэр авагчийн эхнэр/ нөхөр-ийн өндөр насны тэтгэврийн 20 хувиар нэмэгдүүлэх хуулийн дагуу 68 тэтгэвэр авагчдад тэтгэврийн өв олгосон байна.<br>3. Ихэр хүүхэд төрүүлсэн даатгуулагч эхэд тэтгэмж олгох хугацааг 20 хоногоор нэмэгдүүлсэн хуулийн дагуу 12 ээжийн хүсэлтийг хүлээн авч тэтгэмж тооцон олгосон. Мөн тайлант онд нийт 6220 жирэмсэн амаржсны хүсэлт хүлээн авч тэтгэмж бодож олгосон.<br>4. Ажилгүйдлийн даатгалыг тасралтгүй 9 сар шимтгэл төлж эрх хуулийн дагуу 6251 тэтгэмжийн хүсэлт авч шинэчлэсэн хувь, хэмжээгээр бодож олгосон байна.<br>5. Хөдөлмөрийн чадвараа түр алдсны тэтгэмжийн хувь хэмжээгээр 11 714 даатгуулагчдад шинэчлэсэн хувь, хэмжээгээр бодож олгосон байна.<br>6. Сайн дураар даатгуулагч малчны 5 хүртэл жилийн тэтгэврийн даатгалыг шимтгэлийг 50 хувийг төрөөс хариуцах хуулийн дагуу 87 даатгуулагчийн сайн дурын даатгалд хамруулсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7. Байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч байгаа эх /эцэг/-ийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах хуулийн дагуу 372 даатгуулагчийг хамруулсан. | |
| 2.7 | 04/534 | 24/03/19 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Зөвлөмж хүргүүлэх тухай | ХНХ-н сайдын 2020 оны А/169 тушаалаар баталсан Сайн дурын гэрээний хугацаа сунгах тухай журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Нийгмийн Даатгалын Ерөнхий Газраас 2024 оныг хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор болзолт уралдааныг зарлан хэрэгжүүлж ажиллаж байна. 2024 онд энгийн сайн дурын даатгалд 15122, 0-3 насны хүүхдээ асарч буй ээж 1912, сайн дурын малчин 87 даатгуулагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эх 372 нийт 25243 даатгуулагчийг тус тус сайн дурын даатгалд хамруулсан байна. | 100% |
| 2.8 | 01/558 | 24/03/20 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Шилэн дансны зөвлөмж хүргүүлэх тухай | 2023 оны нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд үнэн зөв, хугацаанд нь байршуулах хэрэглэгч мэдээллийг татан авах хэвлэх боломжтой байхаар файлуудыг бэлдэх зэрэг зөвлөмж чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж 2024 оны байдлаар жилд үйл ажиллагааны 171 мэдээлэл оруулахаас 171, сангийн 178 мэдээлэл оруулахаас 178 мэдээлэл оруулсан. Хугацаа хоцорч мэдээлсэн 3, хугацаанд нь мэдээлсэн 175 мэдээ байна. /ХБГ-ээр/ | 100% |
| 2.9 | 01/570 | 24/03/21 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Зөвлөмж хүргүүлэх тухай | Засгийн газрын 2024.02.28-ны 83-р тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу тогтвор суурьшилтай ажиллаж байгаа сумын байцаагч Х.Отгончимэгт урамшуулалыг тооцон 2024.03 сард багтаан олгосон. | 100% |
| 2.10 | 04/588 | 24/03/26 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Зөвлөмж хүргүүлэх тухай | Засгийн газрын 2024 оны 03 дугаар 20-ний өдрийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 120 дугээр тогтоолоор 2024 оны 4 дүгээр сарын 01 өдрөөс 17239 тэтгэвэр авагчдад 14.044.855,9 мянган төгрөг олгосон. | 100% |
| 2.11 | 02/590 | 24/03/26 | Тамгын газрын дарга Б.Батсүх | Тайлбар хүргүүлэх тухай | Тайлбар бичгийн дагуу Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн 2 төрийн албан хаагчийн тэтгэвэр тогтоолгох дээд насны хязгаарт хүртэл ажиллах өөрийн хүсэлтийг хүлээн авч, Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Д.Сэлэнгэ, Хяналт шалгалтын улсын байцаагч Х.Долгормаа нарыг төрийн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албанд үргэлжүүлэн ажиллуулахаар тус газрын даргын 2024 оны Б/18, Б/29 дүгээр тушаалаар баталгаажсан болно. | |
| 2.12 | 04/630 | 24/03/28 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Зөвлөмж хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9.1 дэх заалтын дагуу тэтгэвэр авагчидад зөвлөгөө өгнө ажиллаж байна.2024 оны 2 дугаар улиралын байдлаар 32 нас барсан тэтгэвэр авагчын ар гэр баримт материалаа бүрдүүлэн өгсөн байна.<br>2024.03.28-нд 04/630 тоот “Тэтгэврийн тусгай зохицуулалт хэрэгжүүлэх тухай” зөвлөмж, дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, аргачлал, чиглэлүүдийг тус тус хангаж ажилласан. Энэхүү тэтгэврийн тусгай зохицуулалт 68 тэтгэвэр авагчийн материал хүлээн авч 20 хувиар нэмэгдүүлсэн. | 100% |
| 2.13 | 04/707 | 24/04/05 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Зөвлөмж хүргүүлэх тухай | Зөвлөмжийг ажил олгогч, даатгуулагч, иргэд, тэтгэвэр авагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. | 100% |
| 2.14 | 01/899 | 24/05/01 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаарх зөвлөмж хүргүүлэх тухай | Мэдээллийн ил тод байдлын талаарх зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 2.15 | 04/1187 | 24/06/07 | Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Зөвлөмж хүргүүлэх тухай | Сонгуулийн ухуулагчаар ажилласан иргэнийг сайн дурын даатгалд хамруулан тайлагнах талаар ирүүлсэн зөвлөмж, мэдээллийг нам, эвсэл, нэр дэвшигч нарт хүргэн ажиллаа. | 100% |
| 2.16 | 04/1432 | 24/06/27 | Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Зөвлөмж хүргүүлэх тухай | Орон нутгийн иргэдийн хурлын сонгуулийн хэсгийн хороонд ажиллахаар томилогдсон төрийн албан хаагчийг нийгмийн даатгалд 76001 кодоор тайлагнах талаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу харъяалах сум дүүргийн засаг даргын тамгын газраас нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан. | 100% |
| 2.17 | 01/1688 | 24/08/12 | Ёс зүйн дэд хорооны дарга Ц.Ганцэцэг | Зөвлөмж хүргүүлэх тухай | НДЕГазрын зөвлөмжийн дагуу 41-90 албан хаагчтай байгууллагад Ёс зүйн дэд хорооны 5 гишүүнтэй байх журмын дагуу тус газрын даргын 2024 оны 07 дугаар 05-ны өдрийн А/23 дугаар тушаалаар 5 гишүүнийг томилон ажиллаж байна. | 100% |
| 2.18 | 01/1787 | 24/09/02 | Ёс зүйн дэд хорооны дарга Ц.Ганцэцэг | Зөвлөмж хүргүүлэх тухай | Зөвлөмжийн дагуу Ёс зүйн дэд хорооны холбогдох мэдээ тайланг НДЕГазрын хуулийн мэргэжилтэн М.Гэрэлмаад тогтоосон хугацаанд гарган хүргүүлж ажилласан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.19 | 01/2010 | 24/09/27 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Зөвлөмж хүргүүлэх тухай | Авилгатай тэмцэх газарт гүйцэтгэх ажилтан, мөрдөгч, нууцалбал зохих албаны ажилтнаар ажилласан хугацааг цэргийн албан хаасан хугацаанд оруулан тооцож ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар дүйцүүлэн тооцож хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 2.20 | 03/2477 | 24/11/29 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Зөвлөмж хүргүүлэх тухай | Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын “Удирдах ажилтаны зөвлөгөөн”-д тус газрын дарга Л.Баярням 2024 оны 12 сарын 05-06-ны өдрүүдэд оролцсон. | 100% |
| ***Биелэлтийн дундаж 95 хувь*** | | | | | | |
| *ГУРАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛСЭН АЖЛЫН ЧИГЛЭЛ* | | | | | | |
| 3.1 | 05/11 | 24/01/03 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Тохируулгын зөрүүг сангуудад хуваарилах тухай | Нийгмийн даатгалын сангийн 2023 оны 4-р улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн үйл ажиллагааны урсгал зардал, тохируулгын зөрүүгээр сангуудад хувиарлан жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган хүргүүлсэн. | 100% |
| 3.2 | 01/105 | 24/01/12 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Чиглэл хүргүүлэх тухай | Зөвлөмжийн дагуу ажил олгогч, даатгуулагч, иргэд, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. | 100% |
| 3.3 | 01/107 | 24/01/12 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Тушаалын хэрэгжилт ханган ажиллах тухай | Эрүүл мэндийн сайд,Хөдөлмөр,нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/441,А/192 дугаар хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан “Даатгуулагч,хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь,хугацаа,шалтгааныг магадлах,хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт”-ыг оны эхнээс мөрдөн ажиллаж байна. Тус жагсаалтанд 18 заалт шинээр нэмэгдэж,6 заалт хасагдаж, 40 гаруй заалтанд өвчний код, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь болон хяналтын хугацааг нэмсэн, бууруулсан өөрчлөлтүүд орсон. Тухайлбал: Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох 9 заалтыг “Хугацаагүй” болгож өөрчлөн, сэтгэц болон нүд, арьсны зэрэг өвчний зарим заалтуудын хяналтын хугацааг 24-36 сар болгож нэмэгдүүлсэн байна. | 100% |
| 3.4 | 01/118 | 24/01/16 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Журам хэрэгжүүлэн ажиллах тухай | Тус газарт Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий албан тушаалтан болох 25 Улсын байцаагч ажиллаж байгаа бөгөөд зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан буюу | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын дарга Л.Баярням Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох журмыг сайтар уншиж судлан хэрэгжүүлэн ажиллах талаар нийт эрх бүхий албан тушаалтнуудад чиглэл өгч ажиллаж байна.<br><br>Зөрчлийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орж шинээр 10.17-р зүйлд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг зөрчих тухай 5 заалт нэмэгдсэн бөгөөд 2024 оны 01 сарын 01-нээс мөрдөж эхэлсэн нийт 12 заалтын хүрээнд Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахаар холбогдох хууль тогтоомж болон журмыг судлан тус газрын 25 эрх бүхий албан тушаалтнуудад 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.<br><br>Шийтгэлийн хуудсыг олгох, тайлан тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтныг газрын даргын тушаалаар 2024 оны 01 дүгээр сард томилсон бөгөөд тайлан тооцоог тухай бүр хийж хяналт тавин ажиллаж байна. Тушаалын хуулбарыг хавсралтаар хүргүүллээ.<br><br>Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор батлагдсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ын дагуу шийтгэлийн хуудсыг Аймгийн төрийн сангийн хэлтсээс нэгдсэн дугаарын дагуу хүлээн авч ажиллаж байгаа бөгөөд шийтгэлийн хуудасны тооцоог хагас жилд 7 сарын 05-ны дотор, жилийн эцэст дараа оны 01 сарын 05-ны өдрийн дотор Аймгийн төрийн сангийн хэлтэст батлагдсан хүснэгтийн дагуу тайланг хийж тооцоо нийлэн зөрчилгүй ажиллаж байна. | |
| 3.5 | 01/29 | 24/01/04 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам хүргүүлэх тухай | Хөдөлмөр,нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177,А/433 дугаар хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-ыг мөрдөн ажиллаж байна.Тушаалыг нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн газар, сум,өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам сэдвээр нэгдсэн эмнэлгийн 100 гаруй эмч мэргэжилтэнүүдэд сургалт зохион байгууллаа. | |
| 3.6 | 01/202 | 24/01/26 | Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газрын дарга Д.Цэцэгбадам | Сургалт, сурталчилгааны чиглэл өгөх тухай | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2024 оныг "Нийгмийн даатгалын хамрагдалыг нэмэгдүүлэх жил" болгон зарласан. Ийм Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 бүлэг 20 хэсэгтэйгээр боловсруулж газрын дарга батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг иргэд даатгуулагч, ААН байгууллагад цаг тухай бүр түргэн шуурхай хүргэх зорилгоор ШУУД лайвыг 3 удаа хийж давхардсан тоогоор 21254 иргэн үзэж, 325 асуулт, 616 лайк, 129 шайр хийж, Дархан-уул аймгийн нийгмийн даатгал пэйж хуудас нь Лайк хандалт/LIKE/ 9569, дагагч/FOLLOW/ 12189 болж нэмэгдсэн байна. мэдээллийг түгээж байна.<br><br>Тус газрын Нэг цэгийн үйлчилгээ цахим мэдээллиийн тасгийнхан “Нийгмийн даатгал бол амьдралын баталгаа” сэдвээр тэтгэврийн видео бичлэгт оролцож ,23000 хандалт, 823 түгээлт бичлэгийг хийж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр суртачлан ажиллалаа | 100% |
| 3.7 | 04/243 | 24/02/01 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Шийдвэр хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22 дугаар зүйл “Тэтгэвэр тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа”-нд заасны дагуу 2024 оны байдлаар;<br>• Өндөр насны тэтгэвэр-952<br>• Малчин-10 шинээр тогтоосон байна. | 100% |
| 3.8 | 02/274 | 24/02/06 | Тамгын газрын дарга Б.Батсүх | МУ-н ЗГХЭГ-н зөвшөөрөл олгох тухай албан бичгийг хүргүүлэх тухай | МУ-н ЗГХЭГ-н зөвшөөрөл олгох тухай 2024.02.02 өдрийн 219-р албан бичгийн дагуу 2.1.12 ,3.1.19 дэх заалтын дагуу стандартын шинэ тамга хийлгэн ашиглаж байна. | 100% |
| 3.9 | 04/297 | 24/02/07 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Шийдвэр хүргүүлэх тухай | Зөвлөмжийн дагуу ажил олгогч, даатгуулагч, иргэд, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. | 100% |
| 3.10 | 01/332 | 24/02/16 | Нийгмийн даатгалын ерөнхий | Чиглэл хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын системийн шинэчлэлтэй холбоотой *Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн талаарх | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын дарга Л.Мөнхзул | | тодорхойлолт*-ийг жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах ажил олгогч, мөн банкны зээлд хамрагдах зарим даатгуулагчдад цаасаар гарган өгч ажилласан. | |
| 3.11 | 01/351 | 24/02/21 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах тухай | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Дүрэм батлах тухай” 448 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Эрүүл мэндийн магадлалын дүрэм”- ийг эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа,шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох,хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг эмнэлэг хяналтын комиссын хурлаар хэлэлцүүлэхгүй, эрүүл мэндийн магадлалын хуралд биечлэх ирүүлэхгүйгээр цахимаар болон эрүүл мэндийн баримт бичигт үндэслэн магадладаг болсон өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 3.12 | 04/360 | 24/02/22 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Шийдвэр хүргүүлэх тухай | Жагсаалт журам батлах тухай 471 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган “Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг 1.5 болон 2.5 хувиар төлөх ажил мэргэжлийн жагсаалтыг нийт ажил олгогчид хүргэн ажил олгогчийн тайланг шинэ журмаар авч баталгаажуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаа. | 100% |
| 3.13 | 04/367 | 24/02/23 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Шийдвэр хүргүүлэх тухай | Ажил олгогчийг шинээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэх, бүртгэлийн давтагдашгүй дугаар олгох, даатгуулагчийг шимтгэл төлөгчөөр бүртгэх, дугаар олгох журмыг нийт байцаагч нарт танилцуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 3.14 | 01/376 | 24/02/26 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Чиглэл хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын системийн шинэчлэлтэй холбоотой *Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн талаарх тодорхойлолт*-ийг тендер, тусгай зөвшөөрөл сунгах зэрэг зориулалтаар хүсэлт ирүүлсэн 212 ажил олгогчид цаасаар гарган өгч ажилласан. | 100% |
| 3.15 | 01/403 | 24/02/29 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Журам хүргүүлэх тухай | Шинэ sicos системтэй холбоотой ажил олгогчийн *Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, нөхөн төлүүлэх журам* шинэчлэн батлагдсан талаарх мэдээллийг 1453 ажил олгогчийн удирдлага нягтлан бодогч нарт мэдээлэл хүргэж журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.16 | 05/429 | 24/03/04 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Чиглэл хүргүүлэх тухай | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2023оны жилийн эцсийн тооллогын тайланг 04.01дотор бүрэн оруулж тайлагнасан. | 100% |
| 3.17 | 04/460 | 24/03/06 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Шийдвэр хүргүүлэх тухай | Монгол Улсын ЗГ-ын 2024 оны 138 дугаар тогтоолоор “Малчинд тэтгэвэр тогтоолгох журам” хүчингүйд тооцон “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох сумдын орон тооны бус зөвлөл татан буугдсан.<br>Чиг үүрэг Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлд шилжин ирсэн ба энэ онд өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлээгүй болно. | 100% |
| 3.18 | 01/502 | 24/03/12 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Хяналт шалгалтын удирдамж хүргүүлэх тухай | 2024 онд төлөвлөгдсөн 16 ААНБайгууллагаас өнөөдрийн байдлаар барилга материалын үйлдвэрлэлийн чиглэлийн 2, худалдааны чиглэлийн 2 болон уул уурхайн олборлолтын чиглэлийн 1-д төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийснээс 4 нь бага, 1 нь дунд эрсдэлтэй үнэлэгдлээ. Шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн дундаж 75.9% байсан бөгөөд нийт 32 зөрчил илрүүлж, түүнийг арилгуулахаар 22 заалт бүхий 3 албан шаардлагыг өгсөн, биелэлт ирүүлэх хугацаа болоогүй байна. Одоогоор ажлын байрны тодорхойлолт ирээгүй, мөн байцаагчийн эрх зүйн баримт бичгийн бланк хэвлэгдэж ирээгүй зэрэг шалтгаанаар төлөвлөгөөт шалгалт удаашралтай явагдаж байхын зэрэгцээ шатахуун, томилолт гэх мэт хяналт шалгалтын зардлыг шийдвэрлэж өгөөгүй нь хүндрэл учруулж байна. | 100% |
| 3.19 | 01/503 | 24/03/12 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Хяналт шалгалтын удирдамж хүргүүлэх тухай | Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явагдаж байгаа 4 ААНБ-д төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх шалгалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн байцаагчидтай хамтарч хийлээ. 12 зөрчил илрүүлж 6-г буюу 50%-ийг газар дээр нь арилгуулж ажиллаа. Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа фермер бүхий нэгжүүдээр 8-9 сард төлөвлөгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Хүнс хөдөө аж ахуйн газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газруудын хяналтын байцаагчидтай хамтарч хийхээр төлөвлөж байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.20 | 01/515 | 24/03/15 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Чиглэл хүргүүлэх тухай | 2024.03.15-ны 01/515 дугаар чиглэлийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримтлан бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийг албан ажлын хэрэгцээндээ ашиглаж байна. | 100% |
| 3.21 | 04/559 | 24/03/20 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журам баталсан тухай | ХНХСайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “ Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журам”-ыг нийт байцаагч, мэргэжилтнүүдэд танилцуулан мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. | 100% |
| 3.22 | 04/600 | 24/03/26 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолыг хүргүүлэх тухай | Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, гарааны үлдэгдэл тооцох талаар ирүүлсэн тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 3.23 | 04/639 | 24/03/29 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Шийдвэр хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын холбогдолтой тогтоол, шийдвэр, дүрэм журам, заавар аргачлалын талаар тухай бүр байцаагч ажилтнуудад 7 хоног бүрийн Лхагва гарагт танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 3.24 | 02/643 | 24/03/29 | Тамгын газрын дарга Б.Батсүх | Чиглэл хүргүүлэх тухай | Сонгуулийн хороодод ажиллах албан хаагчдын судалгаа гарган, сургалтад хамруулан газрын даргын 2024 оны Б/35 дугаар тушаалаар МУИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах хэсгийн хорооны дарга, гишүүдээр томилогдсон нийт 11 албан хаагчдад цалинтай чөлөө олгон ажилласан. | 100% |
| 3.25 | 01/660 | 24/04/01 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Чиглэл хүргүүлэх тухай | НДЕГ-ын даргын 2024 оны А/51 дугаар тушаалаар баталсан 43 бүтэц орон тоог шинэчлэн баталж, сул орон тоог Төрийн албаны хуульд заасны дагуу тусгай шалгалтын захиалга өгч 4 албан хаагчийг баталжуулсан. | 100% |
| 3.26 | 01/610 | 24/03/27 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Чиглэл хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024.03.27-ны 01/610 дугаар чиглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 3.27 | 03/452 | 24/03/06 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Шалгалтын удирдамж хүргүүлэх тухай | Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж байгаа 2 ААНБ-д төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх шалгалтыг хийсэн. Хяналтын хуудсаар бага эрсдэлтэй шалгагдсан бөгөөд өнгөрсөн 2023 онд төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан байгууллагууд байсан тул шинэ хуулийн өөрчлөлт болон хяналтын хуудасны нэмэлт шалгууруудын хүрээнд шалгаж зөвлөн туслаж зөрчлийг арилгуулж ажилласан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.28 | 04/689 | 24/04/03 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдтэй хамтран ажиллах Хамтарсан чиглэл хүргүүлэх тухай | НДЕГазар болон ЭМДЕГ “Хамтран ажиллах гэрээ” –г хэрэгжүүлэх “Хамтарсан чиглэл”-ийг ирүүлсэн. Уг чиглэлд эрүүл мэндийн даатгалаа өөрөө хариуцан төлдөг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдахаар ирсэн тохиолдолд регистерийн дугаараа нь www.emd.gov.mn цахим хуудсанд хандан төлбөл зохих шимтгэлийг тооцож, шимтгэлийг цахим төлбөрийн и-баримт системээр төлүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэх талаар байцаагч ажилтануудад танилцуулан сургалт хийж хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 3.29 | 04/702 | 24/04/04 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Шийдвэр хүргүүлэх тухай | ХНХСайдын 2023 оны А/202 дугаар тушаалаар баталсан “Итгэлцүүр хэрэглэх журам”-ыг нийт албан хаагчдад танилцуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэтгэвэр тэтгэмжийн хэлтэст үүрэг болгов. | 100% |
| 3.30 | 01/753 | 24/04/10 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Чиглэл хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 41-р зүйл заасан “Ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ” үзүүлэх зорилтын хүрээнд “Ажил олгогч, даатгуулагчдад зөвлөн туслах үйлчилгээний лавлах утас, цахим хариу үйлчилгээг хэрэгжүүлэхээр Коллпро ХХК тай хамтран ажиллах гэрээ байгуулан 2024 оныг дуусталх хугацаанд лавлах утасны CallPro Voice  CallPro Teams буюу ухаалаг ажлын дугаарыг ашиглан иргэд даатгуулагчдад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж байна. Холбогдох зардлын батлагдсан төсвийн хүрээнд зарцуулан ажиллаж байна. | 100% |
| 3.31 | 05/777 | 24/04/16 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээг мөрдөн хэрэгжилтийг хanган ажиллах тухай | 2024 онд Арилжааны 5 банктай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна | 100% |
| 3.32 | 05/779 | 24/04/16 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Чиглэл хүргүүлэх тухай | Шинэ системд тайлан ирүүлэхтэй холбоотой ажил олгогчоос ажил мэргэжлийн ангилал буруу кодлосон 37 ажил олгогчийн тайлан, тэтгэвэртэй даатгуулагчийн төрөл буруу сонгосон 5 байгууллагын тайланг засварласан. Гэрээний хугацаа буруу 28 даатгуулагч, цалин буруу сонгосон 11 СДД-н гэрээг буцаан засварласан. | 100% |
| 3.33 | 03/785 | 24/04/16 | Дотоод аудит, мониторингийн | Шилэн дансны зөвлөмж хүргүүлэх тухай 01/558 дугаар | Дотоод аудит, мониторингийн газраас ирүүлсэн шилэн дансны зөвлөмжийн дагуу өмнөх оны алдаа зөрчлыг давтан | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын дарга Б.Ганхуяг | албан бичгийг хэрэгжүүлж ажиллах тухай | гаргахгүй байхаар ажлаа төлөвлөн шилэн дансны мэдээллийн үнэн зөв мэдээллийг, хугацаа хоцроогүй байршуулан ажиллаж байна. | |
| 3.34 | 04/892 | 24/05/01 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Чиглэл хүргүүлэх тухай | ХНХСайдын 2024 оны А/80 дугаар тушаалыг үндэслэн тус газрын даргын 2024 оны Б/32 дугаар тушаалаар нийт 18 байцаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгов. | 100% |
| 3.35 | 06/982 | 24/05/10 | Хяналт, шалгалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхагвадорж | Шийдвэр хүргүүлэх тухай | Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2024 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн А/42, А/71 дүгээр тушаалаар баталсан " эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлалыг ЭБАТ-дад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн мэргэжилтэнд үүрэг болгов. | 100% |
| 3.36 | 01/1020 | 24/05/15 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Callpro үйлчилгээний талаар | Нийгмийн даатгалын хэлтэс нь НЭЭЛТТЭЙ ЛАВЛАХ /CALLPRO/ 77057799 утсаар иргэд даатгуулагчдаас нийгмийн даатгал, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт хүлээн авч иргэддээ түргэн шуурхай үйлчлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын газар нь НЭЭЛТТЭЙ ЛАВЛАХ /CALLPRO/ **77057799** утсаар иргэд даатгуулагчдаас нийгмийн даатгал, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт хүлээн авч иргэддээ түргэн шуурхай үйлчлэн ажиллаж байна. CallPro Voice **13798** дуудлага хүлээн авч мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаа. | 100% |
| 3.37 | 09 | 24/05/22 | Мэдээллийн технологийн төв | Даатгуулагчийн цалингийн мэдээллийг хөрвүүлэх тухай | Сайн дурын даатгалын эхний үлдэгдэлтэй регистр зөрүүтэй 3 даатгуулагчийн үндсэн мэдээлэл болон нотлох баримтыг үндэслэн хөрвүүлэлт хийсэн. | 100% |
| 3.38 | 04/1125 | 24/05/30 | Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Шийдвэр хүргүүлэх тухай | ХНХСайдын 2024 оны Тушаалын хавралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай А/87 тушаалаар ХНХСайдын 2023 оны жагсаалт, журам батлах тухай А/221 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун ,хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад өөрчлөлт оруулсан байна. Батлагдсан өдрөөс хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 3.39 | 04/1447 | 24/07/03 | Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Чиглэл хүргүүлэх тухай | Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар, болон Төрийн банк, Хаан банкнаас зээл авах хүсэлт гаргасан "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ний захирал нягтлан бодогчийг нийгмийн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даатгалд хамрагдсан байх шалгуурыг хангасан байх талаар албан хүсэлтийг хүргүүлэн малчны хамралтыг нэмэгдүүлэн ажиллаа. | |
| 3.40 | 01/1546 | 24/07/18 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Чиглэл хүргүүлэх тухай | “2024 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа НД-ын багц хуулийг буцааж хэрэглэх талаар тусгайлан зохицуулаагүй тул 2024 оноос өмнөх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхэд тухайн үед мөрдөж байсан хуулиар шимтгэлийн хувь хэмжээ, ХХТАО зэргийг үндэслэнэ” гэсэн чиглэлийг байцаагч нарт танилцуулж, нийт ажил олгогчдод цахим болон цаасаар мэдээлэл хүргэлээ. | 100% |
| 3.41 | 07/1672 | 24/08/07 | Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтанцэцэг | Журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай | Ажил олгогчид ажиллаж байгаа албан журмын даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох журмыг шинэчлэн баталсан. Энэ журмыг нийт ажил олгогчийн нягтлан бодогчдод мэдээллийг хүргэж мөн нийгмийн даатгалын байцаагч нарт танилцуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100% |
| 3.42 | 01/1739 | 24/08/21 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Чиглэл хүргүүлэх тухай | Ажил олгогч, даатгуулагчдад үйлчлэх “Даатгуулагчийн булан”-г тохижуулан интернет орчинд ажиллах компьютер принтер, байрлуулж ажиллах орчинг бүрдүүлэн ажиллаж байна. | 100% |
| 3.43 | 06/1767 | 24/08/27 | Шимтгэл хураалтын удирдлага, аргазүйн газрын дарга Б.Батсүх | Чиглэл хүргүүлэх тухай | Шимтгэл хураалтын удирдлага арга зүйн газраас ирүүлсэн судалгааг 9 сарын 05-ны дотор гарган хүргүүлж, авлага барагдуулахаар авсан арга хэмжээ болон өрийн барагдуулалтын мэдээг сар бүрийн 01, 15-нд гарган хүргүүлж үр дүнг тооцон ажиллаж байна. | 100% |
| 3.44 | 01/1884 | 24/09/11 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Чиглэл хүргүүлэх тухай | Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд,хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход оролцож байгаа анхан шатны эмч нарыг чадавхижуулах сургалт” сэдэвт Хангайн бүсийн сургалтанд 10 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд ЭММЗ-ийн магадлагч эмч, дотор, мэдрэл, мэс заслын төрөлжсөн мэргэжлийн эмч нарын бүрэлдхүүнтэйгээр амжилттай оролцлоо. | 100% |
| 3.45 | 01/1914 | 24/09/13 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын | Чиглэл хүргүүлэх тухай | НДЕГ-ын даргын 2024.09.13-ны 01/1914 дугаар чиглэлийн дагуу Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж “Зөрчлийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг тооцох журам”-ыг мөрдөн | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | | зөрчилгүй ажиллахыг тус газрын 27 эрх бүхий албан тушаалтанд сургалт мэдээлэл өгч ажилласан. | |
| 3.46 | 01/2032 | 24/10/02 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Чиглэл хүргүүлэх тухай | Тус газар нь Нээлттэй лавлах /CALLPRO/ 77057799 утсаар иргэд даатгуулагчдаас 2024 оны 7 сарын 22-ны өдрөөс хойш CallPro Voice 9354 дуудлага хүлээн авч мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаа. 2024 оны 04 сарын 22-ны өдрөөс callpro үйлчилгээнд шилжин иргэн, байгууллага, авлига гэсэн холбоосоор дамжин 11 байцаагч дуудлага хүлээн авч мэдээлэл, зөвлөгөө хүргэн ажиллаж байна. | 100% |
| 3.47 | 01/2058 | 24/10/03 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Журам хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 24 оны “Журам батлах тухай” 06 дугаар тогтоолоор баталсан “ Ажил олгогчид олгох ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх журам”, “ Ажил олгогчид үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх, хяналт хийх” журамыг нийт байцаагчид танилцуулан, ажил олгогчдод мэдээллийг хүргэн ажиллаа. | 100% |
| 3.48 | 01/2153 | 24/10/18 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Аргачлал хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгон авч буй тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100% |
| 3.49 | 06/2405 | 24/11/21 | Шимтгэл хураалтын удирдлага, аргазүйн газрын дарга Б.Батсүх | Чиглэл өгөх тухай | Нийгмийн даатгалын ерөхний газрын даргын 2024 оны А/162 тушаалаар баталсан “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага барагдуулах, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх аян”-наар авлага барагдуулахаар авсан арга хэмжээ, авлагын бууралтыг аймаг дүүргээр нэгбүрчлэн тооцон гаргаж ажлыг эрчимжүүлэх чиглэл ирсэн тул хэрэгжилтийг ханган ажиллаж аяны хугацаанд авлагыг 5785.9 сая төгрөгөөр бууруулан ажиллаа. | 100% |
| ***Биелэлтийн дундаж-100 /хувь/*** | | | | | | |

| ДӨРӨВ. АЙМАГ, НИЙСЛЭЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛСЭН ҮҮРЭГ ДААЛГАВАР | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | 01/18 | 24/01/03 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Дансны мэдээлэл хүргүүлэх тухай | НДЕГ-ын 2023 оны А/183 тоот тушаалаар Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журмын дагуу төвлөрсөн орлого төвлөрүүлэх дансны мэдээллийг ирүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар арилжааны 5 банк, төрийн сангийн төвлөрсөн орлогын данснаас уг харилцах дансуудад 55 168,1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллаа. | 100% |
| 4.2 | 05/19 | 24/01/03 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Хамтран ажиллах гэрээний биелэлт хүргүүлэх тухай | Хамтран ажилладаг арилжааны 5 банкны гэрээг дүгнэж тогтоосон хугацаанд хүргүүлэв. Тус банкууд 98-100%ийн биелэлттэй гэрээг дүгнэлээ. | 100% |
| 4.3 | 01/83 | 24/01/10 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Судалгаа ирүүлэх тухай | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид сувиллын болон унааны зардал олгосон судалгааг 2024 оны 01 дүгээр сарын 17 өдрийн 44 тоот албан бичгээр хариу хүргүүлэв. | 100% |
| 4.4 | 03/209 | 24/01/29 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Өргөдөл гомдлын мэдээлэл тоон мэдээг хүргүүлэх тухай | Иргэд даатгуулагчаас ирсэн өргөдөл гомдол-79 ирүүлсэн үүнээс;<br>• Иргэд-67<br>• Албан хаагч-12 | 100% |
| 4.5 | 04/213 | 24/01/29 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Төлөвлөгөө хүргүүлэх тухай | Төлөвлөгөөний дагуу сар бүрийн 1-ны өдөр 5 банкаар тэтгэврээ олгож байна. | 100% |
| 4.6 | 05/295 | 24/02/07 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Ажил зохион байгуулах тухай | "Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар" болж өөрчлөгдсөнтэй холбоотой харилцагч банкин дахь нийгмийн даатгалын харилцах дансны нэрийг өөрчлөх нэгдсэн нэг загварын дагуу бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллаа. Арилжааны 5 банкны 22 дансны нэрийг өөрчлөх хүсэлтийг банкуудад хүргүүлэн хэрэгжүүлэн ажилласан. Холбогдох мэдээллийг НДЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Мөн Төрийн сангийн нэгдсэн системд шинэчлэн бүртгүүллээ. | 100% |
| 4.7 | 01/365 | 24/02/23 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Удирдамж хүргүүлэх тухай | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, холбогдох төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, түүний чанар, үр дүнд үнэлгээ дүгнэлт өгч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зорилгоор энэхүү урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтын дүнг газрын даргын зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлж танилцуулг, хавсралт хүснэгтийг хурлын тэмдэглэлийн хамт НДЕГазрын Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. | |
| 4.8 | 03/373 | 24/02/26 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Судалгаа ирүүлэх тухай | •2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хойш шилжиж ирсэн тэтгэвэр авагч-15<br>•2024 оны02 дугаар сарын 01-ний өдрөөс хойш шилжиж явсан тэтгэвэр авагч-8<br>•2024 оны 1 дүгээр сарын 1-ний өрдөөс хойш 6 эсхүл 7 жилийн дундаж цалин хөлсөө 5 жилийн дундаж цалин хөлсөөр өөрчлүүлэхээр хүсэлт гаргасан тэтгэвэр авагч-41<br>•Програмд шийдэгдсэн төлөвт шилжсэний улмаас мэдээллийг нь засварлах боломжгүй байгаа тэтгэвэр авагч-9<br>•Хоёр төрлийн тэтгэвэр авдаг тэтгэвэр авагчийн аль нэг төрлийн тэтгэврийн мэдээлэлд нь алдаа гарч тэтгэвэр нь олгогдоогүй байгаа тэтгэвэр авагч-1 судалгаа хүргүүлэв. | 100% |
| 4.9 | 01/405 | 24/02/29 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Яаралтай ажил зохион байгуулах тухай | SICOS системд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг хөрвүүлэх ажлын хүрээнд ажил олгоч, харилцагч, бүрээр өглөг авлагыг тулган баталгаажуулж тэмдэглэл үйлдэн ЕГ-т тогтоосон хугацаанд нь багтаан хүргүүлэн ажилласан. | 100% |
| 4.10 | 01/446 | 24/03/05 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн зөвлөлийн хуралд оролцсон тухай судалгаа ирүүлэх тухай | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн зөвлөлийн хуралд оролцсон тухай судалгааг хүснэгтээр гарган хүргүүлсэн. Гишүүдийн хуралд оролцсон ирцийн дундаж 95%-тай гарсан ба хуралд оролцоогүй шалтгааныг судлахад УБ хот руу сургалтанд явсан, гадаад ,дотоодод томилтоор ажилласан байлаа. | 100% |
| 4.11 | 03/449 | 24/03/05 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Сангийн яамны Дотоод аудитын хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ирүүлэх тухай | НДЕГ-ын даргын 2023 оны А/133 дугаар тушаалын хэрэгжилтийг дотоод сүлжээгээр ДАМГазарт тогтоосон хугацаанд хүргүүлсэн болно. | 100% |
| 4.12 | 01/514 | 24/03/15 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Ажил зохион байгуулах тухай | Хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. Холбогдох тайланг НДЕГ-т хүргүүлсэн болно. | 100% |
| 4.13 | 01/585 | 24/03/25 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Судалгаа хүргүүлэх тухай | Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хуваан авдаг 6 тэтгэвэр авагчийн судалгааг гарган хүргүүлэв. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.14 | 01/603 | 24/03/26 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Зохион байгуулж, хэрэгжүүлэн ажиллах тухай | НДЕГ-ын даргын 2024 оны 01/603 дугаар чиглэлийн дагуу ажил сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100% |
| 4.15 | 04/665 | 24/04/02 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Санал ирүүлэх тухай | Төсөлд тусгах саналгүй байгааг мэдэгдсэн | 100% |
| 4.16 | 05/703 | 24/04/04 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Тайлан ирүүлэх хуваарь хүргүүлэх тухай | Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн 1-р улиралын тайланг дээд газраас ирүүлсэн хугацаанд хүргүүлэн ажилласан. | 100% |
| 4.17 | 02/708 | 24/04/05 | Тамгын газрын дарга Б.Батсүх | Танилцуулга тайлан ирүүлэх тухай | Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газарт хэрэгжүүлж буй Чанарын менежментийн тогтолцооны 2023-2024 оны тайлан, стандартуудын хэрэгжилтэд үнэлгээ хийн ДАМГазарт хүргүүлсэн. | 100% |
| 4.18 | 04/773 | 24/04/15 | Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг | Малчдын сайн дурын даатгалын хамралтын төлөвлөгөөнд өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан санал ирүүлэх тухай | Малчдын сайн дурын даатгалын хамралтын төлөвлөгөөнд өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан өөрчлөлт оруулах талаарх саналыг хугацаанд албан хүсэлтээр хүргүүлж шинээр хамруулах малчны тоог бууруулсан. | 100% |
| 4.19 | 01/775 | 24/04/15 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Мэдээлэл ирүүлэх тухай | Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран зохион байгуулсан * Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх* талаар 5 сарын 01-03 нд зохион байгуулсан сургалтанд Орлого хамралтын тасгийн дарга Х.Нарангэрэл оролцсон. | 100% |
| 4.20 | 01/788 | 24/04/16 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Сургалт зөвлөгөөнд оролцох тухай | Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтаны зөвлөгөөн 2024.04.25, 26-ны өдөр Улаанбаатар хотд зохион байгуулагдаж тус газрын дарга Л.Баярням зөвлөгөөнд оролцсон. | 100% |
| 4.21 | 01/795 | 24/04/17 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Санал ирүүлэх тухай | Эрүүл мэндийн сайд,Хөдөлмөр,нийгмийн хамгааллын сайдын хамтарсан “Заавар батлах тухай” тушаалын төсөл, даатгуулагч,хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах,хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний зааварт санал хүргүүлж ажиллалаа. | 100% |
| 4.22 | 03/836 | 24/04/22 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Шилэн дансны мэдээлэл байршуулах тухай | Үйл ажиллагаа 171 мэдээ байршуулахаас 171 мэдээ байршуулсан. Нийгмийн даатгалын сангийн 178 мэдээ мэдээлэл байршуулахаас 178 мэдээ байршуулсан.<br>Хугацаа хоцроосон мэдээ-3,<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв, хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулан ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлт гарган зөвлөмж өгч ажилласан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.23 | 01/858 | 24/04/23 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Ажил зохион байгуулах тухай | Монгол банкны зээлийн мэдээллийн санд ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийн мэдээлэл хүргэгддэг. 06 сарын 02-ноос өмнө тухайн авлагыг барагдуулсан тохиолдолд найдваргүй болон муу зээлийн санд мэдээлэл тусгагдахгүй байх талаарх зөвлөгөө мэдээллийг хуримтлагдсан авлага үүсгэсэн 318 АО-ийн удирдлага санхүүд утсаар хүргэж, мөн Байгууллагын сайт **http://www.darkhan-ndaatgal.gov.mn/** **п**эйж хуудсаар дамжуулан түгээсэн. | 100% |
| 4.24 | 06/808 | 24/04/18 | Хяналт, шалгалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхагвадорж | Жагсаалт хүргүүлэх тухай | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Дархан-Уул аймгийн Зэвсэгт хүчний 017 ангид цэргийн алба хаасан 30 хугацаат цэргийн албан хаагчийн мэдээллийг мэдээллийн санд тулгуурлан регистрийн дугаар, ажиллаж байгаа газар, хаягийг тодруулж НДЕГ-ын БХСГ-т хүргүүлсэн болно. | 100% |
| 4.25 | 02/924 | 24/05/06 | Тамгын газрын дарга Б.Батсүх | Тогтоол шинэчлэгдсэнтэй холбогдуулан цахим сургалтад хамрагдуулах тухай | АТГ-аас ЭБАТ-дад зориулсан цахим сургалтад газрын нийт 20 албан хаагч хамрагдсан болно | 100% |
| 4.26 | 02/1034 | 24/05/16 | Тамгын газрын дарга Б.Батсүх | Шударга ёс сэтгүүлд эрдэмтэн судлаачдын бүтээлийг ирүүлэх тухай | Шударга ёс сэтгүүлд илгээх судалгаа болон судлаачдын бүтээл байхгүй болно. | 100% |
| 4.27 | 03/1036 | 24/05/16 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Баримт бичиг ирүүлэх тухай | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Тус газрын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Нээлттэй өгөгдөл мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт байршуулах, хяналт тавих үүрэг бүхий ажилтнаар Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн А.Сансарбаатарыг 2024 оны 10 дугаар сарын 03ны –өдрийн А/27 тушаалаар томилон ажиллуулж байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай” А/20 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг ханган зорилгоор Нээлттэй өгөгдлийг бий болгох, нийтлэх, цахим хуудсанд байршуулах 5 бүлгийн нийт 87 үзүүлэлтийг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнүүлж Шилэн ажиллагааны цэсэд байршуулсан мэдээллээр **Улсын хэмжээнд “ТОП-10” байгууллагын нэгээр** шалгарсан | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.28 | 01/1084 | 24/05/22 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Сургалтад хамрагдах тухай | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогч талууд нь даатгуулагч,хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа,шалтгааныг шийдвэрлэхдээ авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлигын шалтгаан нөхцөл,хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт цахим сургалтанд эрүүл мэндийн магадлалын гишүүдийг 100% хамруулж ажиллалаа. | 100% |
| 4.29 | 01/1090 | 24/05/24 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Эрдэм шинжилгээний бага хуралд оролцох тухай | Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл,АШУҮИС-ийн нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран уламжлал болгон зохион байгуулдаг эрдэм шинжилгээний бага хурлыг “Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааг боловсронгуй болгох нь” сэдвээр 2024 оны 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж байгааг уламжлан албан тоотыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| 4.30 | 03/1109 | 24/05/29 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | 2023, 2024 оны байгууллагын санхүү үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг тус газарт хүргүүлэх тухай | 2023 он болон 2024 оны 1-4 сарын байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн баримт материалыг шалгах ажлын хэсэгт холбогдох баримт материалын хүргүүлэн ажилласан. | 100% |
| 4.31 | 01/1112 | 24/05/29 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Мөнхзул | Төсвийн төсөл, төсөөллийн санал ирүүлэх тухай | Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийн саналыг боловсруулан ажиллаж байна. | 100% |
| 4.32 | 02/1126 | 24/05/30 | Тамгын газрын дарга Б.Батсүх | Дүрэмт хувцасны захиалгын судалгаа ирүүлэх тухай | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд дүрэмт хувцас өмсөх болсонтой холбогдуулан дүрэмт хувцасны захиалгын судалгаа ирүүлэх тухай албан бичгийн дагуу газрын албан хаагчидаас санал авахад “Шилмэл загвар” ХХК-аас хувцас захиалах албан хаагч байхгүй байсан болно. | 100% |
| 4.33 | 05/1406 | 24/06/24 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Тайлангийн тухай | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны эхний хагас жилийн тайланг хуваарийн дагуу бэлтгэн хүргүүлсэн. | 100% |
| 4.34 | 01/1649 | 24/08/05 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Төлөвлөгөө хүргүүлэх тухай | Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024.07.22-ны өдрийн “Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах тухай” 01 тоот албан даалгаврын хүрээнд Төлөвлөгөө батлах тухай А/183 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 14 хоног тутамд тайланг гарган нийт 8 удаагийн тайланг Захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.35 | 03/1671 | 24/08/07 | Захиргаа удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Тайлан ирүүлэх тухай | ***Байгаль орчны менежмент, ногоон ажлын байр MNS 7002:2023 стандартыг шинээр нэвтрүүллээ***.<br><br>Стандартыг нэвтрүүлснээр гарсан үр дүн: *Эрчим хүчний зардлыг 18% буюу 188.0 мян төгрөгөөр, усны хэмнэлтийг 15% иар багасгаж чадсан байна.*<br><br>Энэхүү стандартыг амжилттай хэрэгжүүлж бусад байгууллагуудыг уриалах зорилгоор цуврал *4 видео контентыг* хийж цахим хуудсаараа түгээсэн. | 100% |
| 4.36 | 01/1691 | 24/08/12 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Эрсдэлийн судалгаа ирүүлэх авах тухай | Судалгааг Хуулийн мэргэжилтэн Ц. Мандахбаяр холбогдох газарт гарган хүргүүлэн ажиллав. | 100% |
| 4.37 | 01/1693 | 24/08/14 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Судалгаа ирүүлэх тухай | Анагаах ухааны хүрээлэнгээс “Нугас булчингийн хатангирал өвчний оношилгоонд молекул-биологийн шинжилгээг нэвтрүүлэх” сэдэвт судалгааны ажилд зориулж аймгийн хэмжээнд байгаа эдгээр өвчний оноштой иргэдтэй утсаар ярьж, өөрийн биеэр ирүүлэн бичгээр зөвшөөрөл авч судалгааг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. | 100% |
| 4.38 | 03/1712 | 24/08/15 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Судалгаа авах ажил зохион байгуулах тухай | Нийгмийн даатгалын сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 55 хүүхдийн судалгааг гарган хүргүүлсэн. | 100% |
| 4.39 | 03/1699 | 24/08/15 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Сургалтад тусгах санал хүргүүлэх тухай | Тухайн байгууллагад хүний нөөц болон эрх зүйн чиглэлээр тулгамдаж буй асуудлыг судлан саналыг ЗХГ-т 2024 оны 08 дугаар сарын 23-ны дотор цахимаар хүргүүлэн ажилласан. | 100% |
| 4.40 | 03/1715 | 24/08/16 | Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү | Судалгаа ирүүлэх тухай | Тус газрын албан хаагчдын ажил- ар гэрийн тэнцвэрийн судалгааг нийт 40 албан хаагчаар гарган холбогдох газарт хүргүүлэн ажилласан. | 100% |
| 4.41 | 01/1794 | 24/09/02 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, | Судалгаа ирүүлэх тухай | Монгол Улсын Нийгмийн хамгааллын Олон улсын хэлэлцээрийн дагуу тэтгэвэр тогтоолгон авч байгаа 17 тэтгэвэр авагчийн судалгааг гарган хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | | | |
| 4.42 | 03/1818 | 24/09/04 | Захиргаа удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Сургалт зохион байгуулах тухай | Төрийн байгууллагын албан бичиг солилцооны дундын систем “DocX”-ийг ашиглан цахим хэлбэрээр баримт бичиг солилцох зорилгоор системийг холбох, ашиглах сургалтад ЗХХ-ийн дарга, Мэдээллийн технологийн мэргэжилтэн, бичиг хэрэг, дотоод асуудал, хөрөнгө хариуцсан мэргэжилтэн нар оролцов. | 100% |
| 4.43 | 03/1824 | 24/09/05 | Захиргаа удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Сургалт зохион байгуулах тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газраас ирсэн сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтын төлөвлөгөө гаргаж нийт 32 арга хэмжээг зохион байгуулан тайланг хүргүүлж ажилласан. | 100% |
| 4.44 | 06/1878 | 24/09/10 | Шимтгэл хураалтын удирдлага, аргазүйн газрын дарга Б.Батсүх | Ажил зохион байгуулах тухай | Ажил олгогч байгууллагын дансыг хаасан тохиолдолд дансанд байгаа орлогоос тухайн шимтгэлийн өрийг үл маргах журмаар гаргуулан зохих дансанд төвлөрүүлэн данс нээх зөвшөөрлийг чирэгдэл учруулахгүйгээр банкинд шуурхай хүргэн ажиллахыг өр авлага хариуцсан байцаагч нарт танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100% |
| 4.45 | 02/1935 | 24/09/19 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Судалгаа хүргүүлэх тухай | Тус газарт тэжээгч нь 1995 оноос өмнө нас барсан (*регистрийн дугааргүй, SICOS программ-д оруулах боломжгүй*) тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч байхгүй болно. | 100% |
| 4.46 | 02/1936 | 24/09/19 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Шилэн дансны мэдээллийн тухай | Шилэн дансанд мэдээлэл байршуулах байцаагч албан хаагчдад холбогдох зөвлөмж мэдээллийг танилцуулж хэрэгжүүлж ажилласан. | 100% |
| 4.47 | 07/1956 | 24/09/20 | Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Алтанцэцэг | Тайлангийн хуваарь хүргүүлэх тухай | 2024 оны НДСангийн тайлан шинэчилсэн системд бүртгэхэд зарим бичилт хаагдахгүй байгаа тул 3-р улирлын тайланг хянуулах боломжгүй болж 4-р улиралд тайлангаа хүргүүлэхээр НДЕГ-аас хариуцсан мэргэжилтэн П.Баярцэцэгтэй холбогдон холбогдох заавар зөвлөгөөг авч ажилласан. | 100% |
| 4.48 | 02/1985 | 24/09/25 | Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг | Өргөдөл гомдлын мэдээ ирүүлэх тухай | Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдлын мэдээг хавсралт хүснэгтийн дагуу бэлтгэн 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Дотоод аудит, мониторингийн газарт хүргүүлсэн болно. | 100% |
| 4.49 | 05/2030 | 24/10/02 | Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах | Сургалтад оролцох тухай | Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын хууль тогтоомжийн хэрэглээний ур чадварыг дээшлүүлэх сургалтад 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр цахимаар ЭБАТ-ууд бүрэн хамрагдав. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын дарга Д.Цэцэгбадам | | | |
| 4.50 | 01/2039 | 24/10/03 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Судалгаа ирүүлэх тухай | Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газар нь үйлчлүүлэгч иргэдээс газрын үйлчилгээний сэтгэл ханамжийг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, нээлттэй ил тод үйл ажиллагааг үнэлэх, хүндрэл, хүнд суртал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулах болон ажил үйлчилгээгээ сайжруулахаар авч буй сэтгэл ханамжийн судалгааг худалдааны төвүүд болон хууль сурталчилах сургалтын явцад 200 даатгуулагчаас цаасаар авч үр дүнг тооцон ажилласан. | 100% |
| 4.51 | 08/2075 | 24/10/04 | Хяналт шалгалтын газрын дарга С.Лхагвадорж | Шалгалтын удирдамж хүргүүлэх, ажил эрчимжүүлэх тухай | *Олон улсын байгууллагаа, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн нэгж салбар, төлөөлөгчийн газарт НД-ын хуулийн хэрэжилтэд хяналт шалгалтыг явуулав.*<br><br>40 аж ахуйн нэгжийг өгөгдлийн сангаас шүүн үзвэл Идэвхгүй 27 аж ахуйн нэгж, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 13 аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан.<br><br>5 аж ахуйн нэгжийн 47,560,274.55 төгрөгийн өр авлагыг барагдуулан ажилласан.<br><br>Нийгмийн даатгалын мэдээллийн шинэчилсэн цогц(Core) системийг нэвтрүүлсэнтэй холбоотой Sicos программд 1-5 дугаар сард тогтоогдсон 608 даатгуулагчийн 1,913,361.5 мянган төгрөгийг жирэмсний болон амаржсаны тэтгэмж, 1463 даатгуулагчийн 443,389.0 мянган төгрөгийн хөдөлмөрий чадвар түр алдсаны тэтгэмж, 1462 /давхардсан тоогоор/ даатгуулагчийн 1,694,026.8 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг хянан баталгаажуулж ажиллалаа. Шинээр нэвтэрсэн Sicos системд 6-12 сарын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголт, шилжилт хөдөлгөөн зэргийг оруулахад алдаа магадлал үүссэн эсэх, тэтгэвэр авагчийн сарын тэтгэврийн хэмжээ буюу тэтгэврийн хуваариас өндөр дүнгээр олгогдсон тэтгэврийн олголтыг хувийн хэрэг болон программтай тулган шалгах шалгалт үргэлжилж байна. Дүнг файлаар илгээх болно | 100% |
| 4.52 | 05/2076 | 24/10/04 | Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах | Улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх тухай | Нийгмийнг даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтыг зохион байгуулахтай | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын дарга Д.Цэцэгбадам | | холбогдуулан тус газраас шалгалтад орох 7 байцаагч нарыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллаа. | |
| 4.53 | 01/2101 | 24/10/09 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Сургалт зохион байгуулах тухай | Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд,хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход оролцож байгаа анхан шатны эмч нарыг чадавхижуулах сургалт” сэдэвт Хангайн бүсийн сургалтанд 2024 оны 10 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд ЭММЗ-ийн магадлагч эмч, дотор, мэдрэл, мэс заслын төрөлжсөн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэйгээр амжилттай оролцлоо. | 100% |
| 4.54 | 03/2139 | 24/10/17 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Ёс зүйн хэм хэмжээг хүргүүлэх тухай | 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр МУЗГ-ын 2024 оны 02 тоот тогтоолыг нийт албан хаагчдад танилцуулж ажилласан | 100% |
| 4.55 | 05/2196 | 24/10/24 | Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газрын дарга Д.Цэцэгбадам | Сургалтад хамруулах тухай | Нийгмийнг даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтыг зохион байгуулахтай холбогдуулан НДЕГ-аас зохион байгуулсан цахим сургалтад нийт 7 албан хаагчдыг хамруулан бэлтгэл ажлыг ханган ажиллав. | 100% |
| 4.56 | 03/2272 | 24/11/04 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Үүрэг хүргүүлэх тухай | Монгол улсын Шадар сайдын тушаалаар Гэр бүл,хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран Хүн ам,нийгмийн хамгааллын улсын алба (Гэр бүл, хөдөлмөр,нийгмийн хамгааллын яам)-нд “Команд штабын сургууль”-ийг 2024 оны 11 дүгээр 11-12-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөсний дагуу гамшгаас хамгаалах команд штабын сургууль гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдлага, алба хаагчдад 05:00 цагт “Яаралтай цуглар” зарлан мэдээллийн дохиог өгч, зарлан мэдээллийн дохионы дагуу бэлтгэл, бэлэн байдлыг ханган ажиллалаа.<br>Сургуульд Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Ахмадын хөгжлийн төвийн нийт 53 алба хаагч Дархан-Уул аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын байр, “Хүн ам, нийгмийн хамгааллын алба”-ны штабын байранд цугларч 48 цагийн хугацаанд бэлтгэл сургуулилт хийсэн. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 9 алба | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагч зөвлөн тусалж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллалаа. | |
| 4.57 | 01/2289 | 24/11/06 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Бүртгэл үнэлгээ ирүүлэх тухай | Байгуулагад соёлын өв, дүрслэх урлагын бүтээл, бэлэг дурсгал,эд өлгийн зүйлс бүртгэлгүй болно. | 100% |
| 4.58 | 01/2294 | 24/11/06 | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг | Төлөвлөгөө хэрэгжүүлэн ажиллах тухай | НДЕГ-ын даргын 2024 оны А/48 дугаар тушаалаар баталсан “Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний 2024 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган холбогдох газарт хүргүүлсэн | 100% |
| 4.59 | 05/2371 | 24/11/14 | Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газрын дарга Д.Цэцэгбадам | Тайлан ирүүлэх тухай | Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах ажлын явцын тоон судалгааг хавсралт хүснэгтийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газарт хүргүүлсэн. | 100% |
| 4.60 | 03/2417 | 24/11/22 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчдын тэмдэг, үнэмлэхний хавтас ирүүлэх тухай | Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчдын тэмдэг, үнэмлэхний хавтасыг солиулахаар 2024.11.24-нд НДЕГазарт хүргүүлсэн. | 100% |
| 4.61 | 03/2418 | 24/11/22 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Сургалтад оролцох тухай | Тус газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Т.Буянбат 2024 оны 11 сарын 25-26 өдрүүдэд “Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан сургалтанд хамрагдсан. | 100% |
| 4.62 | 03/2420 | 24/11/22 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Тайлан ирүүлэх тухай | “Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний 2024 оны ажлын төлөвлөгөө”-ний биелэлтийг гарган 2024 оны 11 сарын 25-ны өдөр Захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн. | 100% |
| 4.63 | 03/2437 | 24/11/25 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Сургалтад оролцох тухай | Удирдах ажилтны зөвлөгөөн 2024 оны 12 сарын 5-6-ны өдрүүдэд зохион байгуулагдаж томилолтын зардлыг үйл ажиллагааны урсгал зардлын төсвөөс гаргасан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.64 | 03/2480 | 24/12/02 | Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Даваахүү | Сургалтын төлөвлөгөөний биелэлт ирүүлэх тухай | Нийгмийн даатгалын газрын 2024 сургалтын төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр НДЕГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн болно. Албан хаагчдыг чадавхжуулах дотоод 32 сургалт, иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалыг хууль, тогтоомж таниулах гадагшаа чиглэсэн 32 арга хэмжээ тус тус зохион байгуулан ажилласан байна. | 100% |
| 4.65 | 32/38 | 24/07/18 | Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөлийн дарга Ц.Ганцэцэг | Шийдвэр хүргүүлэх тухай | Дархан сумын 7-р багийн иргэн Б.Пүрэвмаагийн Жирэмсний болон амаржсаны тэтгэмж 2024 оны 8 дугаар сарын 22 өдөр 2,712,680 төгрөг, 2024 оны 9 дүгээр сарын 4 өдөр 2,712,680 төгрөгийг тус тус олгосон. | 100% |
| ***Биелэлтийн дундаж-100 /хувь/*** | | | | | | |
| ***Нийт дундаж-98.7 хувь*** | | | | | | |

ТАНИЛЦСАН
ГАЗРЫН ДАРГА Ш.АРИУНТУЯА

ХЯНАСАН
ЗАХИРГАА ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Т.БАТ-АМГАЛАН

НЭГТГЭСЭН
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН Т.ТӨГСБОЛД